

ОРЧИН ҮЕИЙН ХЯТАДЫН ГЭР БҮЛИЙН БҮТЦЭД ГАРЧ БУЙ ӨӨРЧЛӨЛТ, ТУЛГАРЧ БУЙ АСУУДАЛ

Аззаяа

МУИС-ШУС социологи нийгмийн ажлын тэнхимийн докторант

С Нарантуяа

МУИС-ШУС Социологи нийгмийн ажлын тэнхимийн дэд профессор, доктор

Orcid: 0000-0003-1736-4313

Abstract: Along with economic and social changes, as well as changes in people's thinking, five changes have occurred in Chinese family style and thought, and the concept of family has begun to lose its traditional value. In this paper, we will discuss changes in the family structure, analyze the family problems that result from them, and how to effectively solve and overcome them.

Key words: family structure, family problems, coping strategies.

Гэр бүл гэдэг нь социологийн шинжлэх ухааны салбар судлагдахууны нэг өргөн хүрээтэй ойлголт юм. Социологич, гэр бүл судлаач эрдэмтдийн тодорхойлолтоос харвал “амин биеийн болон оюун санааны хэрэгцээ, нийгмийн шаардлагаар бүрдсэн” (А.Харчев), “ясан болон цусан төрлийн холбоогоор холбогдож, насанд хүрэгчид нь хүүхдийнхээ өмнө хариуцлага хүлээсэн бүлэг хүмүүс” (Э.Гидденс), “цусан төрлийн холбоо, гэрлэлт болон үрчлэлтэнд дулдуйдсан, аж амьдралаа холбож үр хүүхдийн хүмүүжилд харилцан хариуцлага хүлээдэг хүмүүсийн нэгдэл” (Н.Смелзер), “урц сууц, оромж, түүний эзэд, зoorь, цаазлах уул газар нутгийн хамт хамтран багтсан ойлголт” (Д.Гонгор)⁵¹ гэж олон янзаар тайлбарласан байна.

Нийгэм, эдийн засаг, соёлын хөгжил эрчимтэй өрнөж буй өнөө цагт гэр бүлийг дан эхнэр, нөхөр, хүүхэд, эмээ, өвөө гэсэн хүрээллээр ойлгох боломжгүй болжээ. Тиймээс гэр бүл гэдгийг “гэрлэлт, үрчлэлт, цусан төрлийн холбоогоор холбогдож, харилцан үүрэг хүлээж, туслалцан дэмждэг, нэгдмэл ахуй амьдралтай бүлэг хүмүүсийн нэгдэл”⁵² хэмээн ойлгож байна.

Энэ өгүүлэлд Хятадын орчин үеийн нийгэм дэх гэр бүлийн бүтцэд гарч буй өөрчлөлт, тулгарч буй асуудлуудын талаар авч үзэх болно. Өнөөгийн Хятадын гэр бүлийн бүтцийг авч үзвэл дараах хэлбэрүүд ажиглагдаж байна. Үүнд:

Нэгдүгээрт: Ганцаар буюу хоёулхнаа үлдсэн настай хүний гэр бүл

1980 оноос Хятад улсын нэг хүүхдийн бодлого хэрэгжиж эхэлснээс өнөөгийн Хятадад 4/2/1 гэсэн бүтэцтэй гэр бүлийн хэв маяг бий болоод олон арван жил болж байна. 4/2/1 гэх бүтцийг авч үзвэл, дөрөв нь өвөө эмээгийн үе, хоёр нь аав ээжийн үе, нэг нь үр хүүхдийн үеийг төлөөлж байна. Мөн дөрвөн настай хүн гурав дах үе дээрээ ганцхан үр хойчтой болон үлдэж байна. Өөрөөр хэлбэл нэг хүүхэд нь эцэг эх, дөрвөн өвөө эмээгээ асарч халамжлах ёстой болж ирж байна. Өмнө нь Хятадад ахмад настныг асран хамгаалах нь тухайн гэр бүлийн үүрэгт ажил гэж үздэг байсан бол өнөөгийн гэр бүлийн бүтцэд гарсан өөрчлөлтийн улмаас ахмад настнуудыг асрах энэ уламжлалт хандлага нь алдагдах болсон.

Иймээс цөөн хүүхэд төрүүлсэн, төрсөн хүүхдүүд нь тусдаа амьдардаг зэрэг шалтгаанаас болж, ганцаараа буюу хоёулхнаа үлдсэн ахмад настны гэр бүлийн тоо олширсон. Мөн нөгөө талаас

⁵¹ Т.Бурэнжаргал. “Гэр бүлийн социологи” УБ., 2005. 7 дах тал

⁵² Мөн тэнд. 8 дах тал

Хятадын нийгмийн байдал сайжирч, улмаар эмнэлгийн салбар хурдацтай хөгжиж чанар, үйлчилгээ сайжирснаар хүн амын дундаж наслалт нэмэгдэх болсон. Хятад улс өнөөдөр дэлхий дээр ахмад настай хүний тоогоор тэргүүлэх болжээ. 2021 оны статистикийн дүнгээс авч үзвэл, Хятад улсын бүх хүн амын 20 хувийг жараас дээш насныхан эзэлж байна. Үүнтэй уялдан Хятадын засгийн газраас ахмад настны хувийн асрамжийн газруудын тоо, хүртээмжийг нэмэгдүүлэх, чанар үйлчилгээг сайжруулах, улмаар хувийн асрамжийн газруудын үйл ажиллагааг дэмжиж, татварын хэмжээг хөнгөлөх зэрэг арга хэмжээг авах нь зүйтэй байна.

Хоёрдугаарт: Амьдралынхаа туршид гэр бүлтэй болохгүй ганц биеэр амьдрах сонголт хийж буй хүмүүс

Хятадын нийгэм дэх хүйсийн тэнцвэргүй байдал, гэрлэлтийн өндөр өртөг зэрэг нь тухайн гэр бүлийн амьдралын дарамт болж, залуучуудын гэрлэлтийн талаарх үзэл бодол өөрчлөгдөж ганц биеэр амьдрах хүсэлтэй хүмүүсийн тоог нэмэгдүүлэхэд хүргэж байна. Энэ байдал нь уламжлалт гэр бүлийн талаарх ойлголтыг өөрчилж, Хятадын түүхэнд байгаагүй гэр бүлийн онцгой хэв маягийг бий болгож байна. 2022 оны статистикийн дүнгээс авч үзвэл, ганц биеэр амьдарч буй хүмүүсийн тоо 240 саяд хүрээд байна. Энэ нь Хятадын бүх хүн амын 17 хувийг эзэлж ганц бие хүмүүсийн бүлгийг бий болгоод байна. Мөн энэ байдал том хотууддаа улам ихсэх хандлага ажиглагдаж байна. Эдгээр хүмүүсийн онцлогийг авч үзвэл хотынхны хувьд тэд гэр бүлийн үүрэг хариуцлагыг хүлээхээс илүүтэй хөрөнгө мөнгө, цаг хугацаа, оюун санаагаа зөвхөн өөрийн сайн сайхан байдлын төлөө зориулах хүсэлтэй байна. Харин хөдөө тосгонд мал аж ахуй, газар тариалан эрхэлдэг залуусын хувьд бол эхнэр олдхоггүй байх нөхцөл үүсээд байна. Үүний шалтгааныг авч үзвэл, нэг талаас ихэнх эмэгтэйчүүд сургууль соёлын мөр хөөж хот суурин газрыг сонгох болж хөдөө орон нутагт үлдэх эмэгтэйчүүдийн тоо багассан, нөгөө талаас эхнэр авахад их хэмжээний хөрөнгө мөнгө буюу инж зарцуулдаг Хятадын уламжлал нь хадгалагдсаар байгаа нь бас нөлөөлж байна.

Ганц биеэр амьдрах хүсэлтэй эдгээр хүмүүст гэр бүлийн үнэ цэнийг мэдрүүлэх, ганц бие хүнд тулгарч болох асуудалд нийгмийн зүгээс анхаарал хандуулах шаардлага урган гарч байна. Улмаар энэ байдал нь Хятадын хүн амын өсөлтөд нөлөөлөх асуудал болж байна.

Гуравдугаарт: Хүүхэд төрүүлж өсгөхийг хүсдэггүй хосууд

2023 оны статистикийн дүнгээс үзвэл Хятадад хүүхэдгүй хүмүүсийн тоо 190 саяд хүрч, энэ нь гэр бүл болсон хүмүүсийн 38 хувийг эзэлж байна. Ийм гэр бүлийн дийлэнх буюу 80 хувь нь дээд боловсролтой гэр бүл байна. Залуу гэр бүлүүд цаг завгүй их хөдөлмөр, мөн орон сууц, боловсрол, эрүүл мэндийн өртөг, эдийн засгийн дарамтаас эмээж хүүхэд төрүүлж өсгөхийг хүсдэггүй байна. Сүүлийн үед Хятадад 3 хүүхдийн бодлогыг хэрэгжүүлэх асуудал яригдаж байгаа хэдий ч дээрх шалтгаанаас болоод энэ бодлогыг хэрэгжүүлэх боломж хомс байна. Жишээлбэл 1950-иад онд Хятадын нэг гэр бүл дэх хүний тоо 5-6 байсан бол, одоо энэ байдал өөрчлөгдөж, нэг гэр бүл дэх хүний тоо 2-3 болжээ.

Хүүхэдгүй гэр бүлийн нөхцөл байдал өнөөгийн Хятадын нийгмийн тулгамдсан асуудлын нэг болоод байна. Энэ нь тэд харгалзах хамаарах хүн байхгүйгээс болж тэднийг залилан мэхлэх явдал гарч, тэд амьдралынхаа туршид хуримтлуулсан эд хөрөнгөө үлдээх үр удам байхгүй болж байна. Мөн тэд сэтгэл санааны дарамтанд орж, амьдралын утга учир, үнэт зүйлгүй болж, “хүүхэдгүй” гэж нэрлэгдэх, хэл аманд өртөх, улмаар амиа хорлох хандлага ихсэж байна. Энэ байдал нь хятадын нийгэмд шинэ тутам асуудал болон гарч ирж байна.

Дөрөвдүгээрт: Ганц хүүхэдтэйгээ шалтгаалсан гэр бүлийн асуудал

2022 оны Хятадын тоо баримтаас харвал 200 сая хүн айлын ганц хүүхэд байна. Ганц хүүхэдтэй байх нь Хятадын гэр бүлийн онцлог. Энэ байдлаас шалтгаалж тухайн гэр бүлийн үе хоорондын хүүхдийн

нийгэмшил, хүмүүжлийн асуудал бас тулгамдаад байна. Үүнийг тайлбарлавал, нэг хүүхдийг 6 том хүн өсгөж, эрх дураар нь байлгаж, булаацалдаж, тэд өөр өөрсдийн арга барилаар хүмүүжүүлэх хандлагатай байдаг нь гэр бүлийн зөрчилдөөний асуудал болж байна. Энэ нь хүүхдийн нийгэмшилд сөргөөр нөлөөлж нийгмийн орчиндоо зохицох чадвар муутай, сэтгэлийн тэнхээгүй, тэсвэр тэвчээргүй, амиа хичээх үзлийг бий болгож, хариуцлагагүй, өрөвч сэтгэлгүй хүх болон нийгэмшиж байна. Тэд мөн сэтгэл зүйн дарамтад орж байгаа ба Хятадын амиа хорлосон хүмүүсийн ихэнх нь айлын ганц хүүхдүүд байна гэсэн судалгааны үр дүн байна.

Мөн Хятадын хүн амын шилжилт хөдөлгөөн нь ганц хүүхдийн нийгэмшилд нөлөөлж байна. Залуу эцэг эх нь хот суурин газарт ажиллаж амьдарч, үр хүүхэд нь хөдөө тосгонд өвөө, эмээтэйгээ амьдардгаас болж, хүүхэд эцэг эхтэйгээ хот хөдөөгийн хооронд салан тусгаарлагдаж байна.

Тавдугаарт: Гэр бүл салалт

Хятадын гэр бүл салалтын түвшинг авч үзвэл жил тутам гэрлэсэн гэр бүлийн 50 хувь гэрлэлтээ цуцлуулж байна. Сүүлийн жилүүдийн гэр бүл салалтын тоог авч үзвэл 2019 онд хамгийн их буюу 4.7 сая гэр бүл гэрлэлтээ цуцлуулжээ.

Гэр бүл салалтыг насны хувьд авч үзвэл, 1980, 90 ээд онд төрсөн хүмүүс гэр бүл салалтын гол цөм болж байна. Энэ нь нэг хүүхдийн бодлоготой холбоотой гарч ирсэн асуудлын нэг гэж үзэж болно. Үүний шалтгааныг авч үзвэл, нэгдүгээрт тэд гэр бүлдээ ганц хүүхдүүд байсныхаа хувьд бага наснаасаа элбэг хангалуун сайн сайхан амьдрах нөхцлөөр хангагдаж, энэ байдал нь насанд хүрсэн хойноо амьдралыг даван туулах чадвар багатай болгож байна. хоёрдугаарт, мэдээллийн эрин зууны хөгжилтэй холбоотой хосууд хоорондын дотно харилцаа холбоо, ойлголцол дутмаг болсон нь гэр бүл хэмээх ойлголтын үнэ цэнийг ганхуулж байна. Гуравдугаарт, сүүлийн жилүүдэд хосууд гэр бүлдээ хүндэтгэлтэй хандахгүйн улмаас зарим залуус гэр бүлээ хууран мэхлэх, гэр бүлийн зөрчлөө хамтран шийдвэрлэхгүй зэрэг нь гэр бүл салалтад хүргэж байна.

Гэр бүл салалтын түвшин өндөр байгаа асуудлыг шийдэхийн тулд гэр бүлийн үнэ цэнийг таниулж зөв ойлголттой болоход нь туслах, гэрлэлтээ цуцлуулахаар ирсэн тохиолдолд салалтын сул талыг ойлгуулан эвлэрүүлэх арга хэмжээ авах шаардлагатай байна.

Дээр дурьдсан өөрчлөлт нь орчин үеийн Хятадын гэр бүлийн гол асуудал болж байгаа бөгөөд Хятад улсын онцлогийг харуулж байгаа юм

Нийгмийн хөгжлийг дагаад гэр бүлийн бүтэц, гэр бүлийн асуудал байнга өөрчлөгдөж байдаг. Нийгмийн хурдацтай өөрчлөлтийн явцад Хятадын гэр бүлд их өөрчлөлт гарсан ч бас уламжлалт гэр бүлийн зарим шинж чанар хадгалагдсаар байна. Жишээ нь хайр, бэлгийн амьдрал, хүн амын нөхөн үржихүй, хүний нийгэмшилт, ахмад настанг асрах зэрэг нийгмийн үүргээ гэр бүл гүйцэтгэсээр байна.

Ном зүй

1. Пэн Хуамин, Ян Синхен: *Социологийн танилцуулга, Бээжин: Дээд боловсролын хэвлэл, 2006.*
2. Ма Гуочин, *Үндэсний долоо дахь тооллогын дүн шинжилгээ: Орчин үеийн Хятад дахь гэр бүлийн өөрчлөлт: шинж чанар, чиг хандлага, хэтийн төлөв, "Хүн амын судалгаа", 2023 оны 1-р сар.*
3. Ян Жухуа ба Хэ Жанхуа, *Нийгмийн өөрчлөлтийн үйл явц дахь гэр бүлийн өөрчлөлт ба залгамж чанар, "Хүн амын судалгаа" 2014 оны 2-р дугаар.*
4. Фэй Шиаотун, Шаньдун Кадре Корреспонденцийн Их Сургуулийн *"Социологийн лекцийн тэмдэглэл" сэтгүүл, 2019 оны 09-р дугаар.*
5. Лин Бао: *Тэтгэврийн баталгаа, үйлчилгээний тогтолцоог сайжруулж, хүн амын хөгшрөлтөд идэвхтэй хариу арга хэмжээ ав, "Хятадын хүн ам зүй", 2023 оны 4-р дугаар.*